# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# Т О Г Т О О Л

2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 361

Улаанбаатар хот

Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 12.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ажилгүйдлийн даатгалын сангаас мэргэжил олгох болон давтан сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг 150,000 (нэг зуун тавин мянган) төгрөг байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд — А.АРИУНЗАЯА